

**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ИНЖЕНЕРИЙН
АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ**

**ХАРИУЦАХ НЭГЖ: УДИРДЛАГУУД, ДОТООД АУДИТОР, НЭГДСЭН ЦЕХ, АВТО ХҮНД МАШИН
МЕХАНИЗМЫН ХЭСЭГ, ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТЭС, САНХҮҮ,
ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТЭС, АЖ АХУЙ, ХАНГАМЖИЙН ХЭЛТЭС,
ИНЖЕНЕРИЙН ХЭСЭГ, ХЯНАЛТЫН ХЭЛТЭС**

А. АЖЛЫН БАЙРНЫ ТАНИЛЦУУЛГА

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:	
Амгалан дулааны станц ТӨХК	Хяналтын хэлтэс	
Ажлын байрны нэр:	Ангилал	Зэрэглэл
Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн инженер	ИТА	
Шууд харьяалагдах ажлын байрны нэр /албан тушаал/	Шууд харьяалах нэгж, ажлын байрны нэр /албан тушаал/	
Хяналтын хэлтсийн дарга	-	
Орлон ажиллах албан тушаалтан	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер	

Б. АЖЛЫН БАЙРНЫ ЧИГ ҮҮРЭГ

1. Албан тушаал /ажлын байр/-ын зорилго	- Хариуцсан нэгжийн үйл ажиллагаанд ХАБЭА-н тухай хууль, ГАБ-ын тухай хууль, Онц байдлын тухай хууль, Авто тээврийн тухай хууль, Гамшигаас хамгаалах тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, эрчим хүчний салбарт мөрдөгддөг дүрэм, журам, заавар, стандартын хэрэгжилтийг хангуулах. - Амгалан дулааны станцын хэмжээнд Гамшигаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангуулах, тайлан мэдээг нэгтгэж, холбогдох байгууллага, албан тушаалтанд цаг хугацаанд нь хүргүүлэх, Гамшигаас хамгаалах штаб, мэргэжлийн анги бүрэлдэхүүний ажлын төлөвлөгөөг гаргах, ажил үүргийг зохион байгуулах. - Амгалан дулааны станцын хэмжээнд ХАБЭА-н талаарх ажлын төлөвлөгөө, тайлан, мэдээг нэгтгэн гаргах, холбогдох байгууллага, албан тушаалтанд цаг хугацаанд нь хүргүүлэх. - Ажилчдын цайны газрын эрүүл ахуй, ариун цэвэрт хяналт тавих бөгөөд мэргэжлийн байгууллагаар хоолны чанарт хяналт тавиулах. - Станцын хэмжээнд Галын аюулгүй байдал, гамшигаас хамгаалахтай холбоотой сургалтыг зохион байгуулах, станцын галын аюулгүй байдлын дүгнэлтийг холбогдох байгууллагаар цаг хугацаанд нь гаргуулах.
2. Ажлын байрны үндсэн чиг үүрэг	А. Хариуцсан нэгжид дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд: - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг нэвтрүүлэх. - ХАБЭА-н талаар гарсан дүрэм, журам, заавар, стандартын мөрдөлтөнд хяналт тавих, осол аварга, саатлаас урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг арилгуулах. - Галын аюулгүй байдлын стандартыг нэвтрүүлэх, эрчим хүчний системд мөрдөгддөг Галын аюулгүй байдлын талаар гарсан дүрэм, журам, заавар, стандартын мөрдөлтөнд хяналт тавих, хариуцсан объектын галын аюулгүй байдлыг хангуулах, гал түймрээс урьдчилан сэргийлэх, гарсан

	гал түймрийг богино хугацаанд түргэн шуурхай унтраах, галын багаж хэрэгсэлийн бэлэн байдлыг хангуулах. 4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Галын аюулгүй байдал, экологийн чиглэлээр сургалтын болон шалгалтын материалын баазтай байх. 5. Амгалан дулааны станц ТӨХК-ийн бодлого, үйл ажиллагааны хэтийн төлөвлөлттэй уялдуулан хариуцсан ажил үүргээ оновчтой зөв зохион байгуулж, өндөр үр ашигтай ажиллахад өөрийн хувь нэмрийг оруулахын зэрэгцээ шинийг санаачилж ажиллах. 6. ХАБЭА, Галын аюулгүй байдлын эрсдэл, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр цех, хэсгүүдтэй хамтран ажиллах. 7. Ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцлийг хангах, осол аваараас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах. 8. Үйлдвэрлэлийн осол, технологийн зөрчлийг дүрмийн дагуу судлан бүртгэх, акт тогтоож заасан хугацаанд залруулах арга хэмжээг зохион байгуулж биелэлтийг хангуулах. 9. Хууль, дүрэм, журам, заавар, стандартын дагуу ажилтнуудын мэдлэг шалгах тестийг алдаагүй, үнэн зөвөөр, оновчтой боловсруулж, батлуулах. 10. Хариуцсан нэгжийн ХАБЭА-н сургалтын нэгдсэн тайланг гаргах, нэгтгэлд хугацаанд нь өгөх. 11. Хариуцсан нэгжийн экологи болон ногоон байгууламж бүрдүүлэлтэд хяналт тавих. 12. Хариуцсан нэгжийн галын аюулаас урьдчилан сэргийлэх ажилд хяналт тавих. 13. Авто болон өөрөө явагч тээврийн хэрэгслийн жолооч, нарын жолоодох эрх, эрхийн үнэмлэхэд хяналт тавих. Б. Амгалан дулааны станцын хэмжээнд дараах үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд: 1. Амгалан дулааны станцын хэмжээнд Галын аюулгүй байдал, Гамшигаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангуулах, тайлан мэдээг нэгтгэж, холбогдох байгууллага, албан тушаалтанд цаг хугацаанд нь хүргүүлэх. 2. Гамшигаас хамгаалах штаб, мэргэжлийн анги бүрэлдэхүүний ажлын төлөвлөгөөг гаргах, ажил үүргийг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах. 3. Амгалан дулааны станцын Галын аюулгүй байдал, гамшигаас хамгаалахтай холбоотой сургалтыг зохион байгуулах, станцын галын аюулгүй байдлын дүгнэлтийг холбогдох байгууллагаар цаг хугацаанд нь гаргуулах. 4. Амгалан дулааны станцын хэмжээнд ХАБЭА-н талаарх төлөвлөгөө, тайлан, мэдээг нэгтгэн гаргах, холбогдох байгууллага, албан тушаалтанд цаг хугацаанд нь хүргүүлэх, 5. Компанийн үнэт зүйлс, нэр хүндийг хадгалах. 6. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг цаг хугацаанд нь биелүүлэх. 7. Компанийн хэмжээнд зохион байгуулагдсан арга хэмжээнд идэвхитэй оролцох. 8. Станцын өргөтгөл, төслийн үйл ажиллагааны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах.
3.Үндсэн үүргийн хүрээнд ажлын байранд хийгдэх ажлууд	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр: 1. Ажилтнуудад урьдчилсан зааварчилгаа, нэгжийн удирдлагад ажлын байрны анхан шатны болон ээлжит бус зааварчилгаа өгөх, ажилтнуудад ажлын байрны, давтан, тухайлсан, ээлжит бус зааварчилгаа өгч буйд

хяналт тавих, зааварчилгаа өгөх явцад гарсан зөрчлийг тухай бүр нь арилгуулах.

2. Ажилтнуудаас ААД, ТАД, ГАБД-ийн ээлжит болон ээлжит бус шалгалт авч, үнэмлэхний сунгалт хийх.
3. Нарядын системийг мөрдүүлэх, ажлын байранд наряд авч ажилд орсон эсэхэд хяналт тавих.
4. ХАБЭА-н дүрэм, журам, заавар, стандартыг мөрдүүлэх.
5. Ажлын хувцас, хувийн нэг бүрийн хамгаалах хэрэгслэлийн олголт, хэрэглээ, эдэлгээнд хяналт тавих.
6. Осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх (осол, зөрчлийн давтамж, хохирлын хэмжээ) болон осол, зөрчил, осолд дөхсөн тохиолдлын бүртгэл хөтлөх, түүнийг арилгуулах, тогтоосон хугацаанд тайлан, мэдээг гаргаж, холбогдох газарт хугацаанд нь хүргүүлэх.
7. Мэргэжлийн сургалтын байгууллагуудтай хамтран ажиллах.
8. Хариуцсан цех, хэсгийн ажилтнуудад төлөвлөгөөний дагуу ХАБЭА-н сургалт зохион байгуулах, үйлдвэрлэлийн аваари, осол, зөрчил гарсан тохиолдолд ээлжит бус сургалт, шалгалтыг зохион байгуулах.
9. Ажлын байрны нөхцөлийг шат дараатай сайжруулах ажлыг зохион байгуулж, үр дүнг гаргах.
10. Ажлын байр болон ахуйн байрны нөхцөлийн хэмжилтийг батлагдсан хуваарийн дагуу хийж, нөхцөлийг стандартын дагуу болгох талаар шаардах.
11. Ажлын байрны нөхцөлд тохирсон хор саармагжуулах бүтээгдэхүүний норм тогтоолгох, хэрэглээнд нь хяналт тавих.
12. Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийлгэх, үнэлгээ хийж буйд хяналт тавих.
13. Тоног төхөөрөмж, багаж хэрэгслэлийн ашиглалтын заавар, схем, түүний баталгаажуулалт, параметруудад хяналт тавьж ажиллах.
14. Технологийн онцлогоос хамаарсан аюулгүй ажиллах шаардлагыг ажил гүйцэтгэгч нарт тавих, биелэлтэнд нь хяналт тавих.
15. Өдөр тутамын болон 2-р шатны үзлэгт хяналт тавих, 3-р шатны үзлэгийг тогтоосон хугацаанд тогтмол зохион байгуулж, үл тохиролыг цаг хугацаанд нь залруулах.
16. Засвар үйлчилгээ хийх эрх бүхий ажилтнуудын бие даан ажиллах эрхийг баталгаажуулах.
17. Эрхэлсэн ажлын чиглэлээр төр засаг, дээд шатны эрх бүхий хяналтын байгууллагаас гаргасан тогтоол шийдвэр, албан шаардлага, даалгавар, акт, заавар зөвлөмжийг мөрдүүлэх ажилд оролцож хяналт тавих.
18. Ажилтнуудад ажлын чиглэл, үүрэг даалгавар өгөхдөө уг ажлыг аюул осол, зөрчилгүй гүйцэтгэх талаар үүрэгжүүлж, биелэлтэнд хяналт тавих.
19. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар ирүүлсэн асуудал, санал, хүсэлт, шаардлагыг хүлээн авч цаг алдалгүй судлан шийдвэрлэх, хугацаанд нь хариу өгч биелэлтийг хангах.
20. Хариуцсан нэгжийн ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөлтэй уялдуулан эрүүл мэндийн ээлжит болон ээлжит бус үзлэг шинжилгээнд бүрэн хамруулах, үзлэг шинжилгээний дүнг үндэслэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах.
21. Эрүүл мэндийн үзлэгээр өвчлөлтэй гарсан ажилтнуудын эрүүл мэндэд хяналт тавих.
22. Ажлын байранд халдварт өвчин гарсан үед тусгаарлах арга хэмжээг авч, гамшигийн үед хэрэгжүүлэн ажиллах төлөвлөгөөний дагуу шуурхай ажиллах.
23. Нийтийн хоолны газарт мөрдөгдөх стандартын хэрэгжилтэнд хяналт тавих.
24. Компанийн цайны газрын цахилгаан, газаар ажилладаг тоног

	төхөөрөмжүүдийн аюулгүй байдал, галын аюулгүй байдалд хяналт тавьж ажиллах. Галын аюулгүй байдлын чиглэлээр: 1. Амгалан дулааны станцын хэмжээнд Галын аюулгүй байдал, Гамшигаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангуулах, тайлан мэдээг нэгтгэж, холбогдох байгууллага, албан тушаалтанд цаг хугацаанд нь хүргүүлэх. 2. Гамшигаас хамгаалах штаб, мэргэжлийн анги бүрэлдэхүүний ажлын төлөвлөгөөг гаргах, ажил үүргийг зохион байгуулах. 3. Амгалан дулааны станцын хэмжээнд Галын аюулгүй байдал, гамшигаас хамгаалах сургалтыг зохион байгуулах. 4. Компанийн галын аюулгүй байдлын дүгнэлтийг холбогдох байгууллагаар цаг хугацаанд нь гаргуулах. 5. Ажлын байрны галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бусаар хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах. 6. Байгалийн гамшиг, экологийн мэдлэг, байгаль орчиноо хамгаалах, гал түймэртэй тэмцэх, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, гал түймэр унтраах арга ажиллагаа, хууль, тогтоомж, дүрэм, журмаар, сургалт явуулж, мэдлэгийг нь дээшлүүлэх төлөвлөгөө боловсруулж ажиллах. 7. Галын аюулгүй байдал, байгалийн гамшиг, байгаль орчины бохирдол, түүний аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх ажилд хяналт тавих. 8. Барилга байгууламж бүрт гал унтраах тоног төхөөрөмж, анхан шатны багаж хэрэгсэл, бодис, материал байрлуулсан эсэхэд хяналт тавих. 9. Гал түймрийн хэрэг зөрчлүүдийг бүртгэж судалгаа гаргаж, ажилтнуудад мэдээлэл өгч, хор хөнөөлийг ойлгуулах. 10. Гал түймэр гарах, хүний амь нас хохирох, осол гарах, эд материалын хохирол учруулах нөхцөл бүрдсэн тохиолдолд гүйцэтгэж буй ажлыг нь шууд зогсоох, удирдлагад нь мэдэгдэж, шат дараалсан арга хэмжээ авах. 11. Галын зөрчил, доголдлын шалтгааныг тогтоох, акт бичих, хариуцлага тооцуулах, хугацаатай үүрэг өгөх. 12. Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, ЭХХТ, мэргэжлийн байгууллагаас тавьсан албан шаардлага, зөвлөмжийг биелүүлэх төлөвлөгөө гарган биелэлтийг зохион байгуулах. 13. Гал түймрийг унтраахад ажилтнууд, техник хэрэгслийг дайчлан ажиллах. 14. Галын аюулгүй байдлыг хангах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн хуулийн этгээдээс арга зүйн тусалцаа, зааварчилгаа, зөвлөгөө авах. 15. Гал түймрийн аюулгүй байдлыг хангах талаар удирдах байгууллага болон мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, тодорхой шийдвэр гаргахад оролцох. 16. Галын аюулгүй байдлыг хангах талаар гарсан тушаал шийдвэрийн биелэлтэд хяналт тавих.
--	--

В. АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролтой байх.
Мэргэжлийн бэлтгэл	Эрчим хүчний инженер мэргэжилтэй байх.
Мэргэшлийн бэлтгэл	ХАБЭА-н чиглэлээр сургалтанд хамрагдаж, үнэмлэхжсэн байх.
Туршлага	Эрчим хүчний үндсэн үйлдвэрлэлд 7-оос доошгүй жил ажилласан байх.
Ур чадвар	• Шударга, зарчимч, хууль дүрмийн дагуу ажлаа зохион байгуулдаг байх, • Баримт бичгийг компьютер, техник хэрэгсэл ашиглан алдаагүй төлөвлөж чаддаг байх. Бичиг баримт боловсруулах өндөр чадвартай байх,

	• Хурал, зөвлөгөөн, сургалтыг зохион байгуулах чадвар эзэмшсэн байх. • Харилцааны өндөр соёлтой, • Танилцуулга хийх ур чадвартай, • Ярих, бичих, гарч буй өөрчлөлтөнд зохицон ажиллах чадвар эзэмшсэн байх, • Үр дүнтэй харилцаа тогтоох чадвартай, • Багаар ажиллах чадвартай, • Компьютерийн хэрэглээний программыг бүрэн эзэмшсэн байх, • Ажилдаа орчин үеийн техник хэрэгслийг сайн ашиглах чадвартай, • Хууль эрх зүйн мэдлэгтэй, • Шаардлага зөв тавьж чаддаг байх, • Үнэлэлт, дүгнэлт хийж, зөв шийдвэр гаргах чадвар эзэмшсэн байх, • Архив, бичиг хэргийг стандартын дагуу хөтлөдөг байх, • Хэрэглээний оффиссе программууд дээр ажиллах чадвартай байх. <u>Зайлшгүй мэдвэл зохих зүйлс:</u> ➤ Хууль эрх зүйн 1. МУ-ын Эрчим хүчний тухай хууль, 2. МУ-ын ХАБЭАТ хууль 3. Хөдөлмөрийн тухай хууль, 4. Компаний дотоод журам, 5. ТАД, ААД, ГАБД, НСД
Тусгай шаардлага	Ёс зүйн хэм хэмжээг хэлбэрэлтгүй сахиx, байгууллагын нууц хадгалах, харилцааны өндөр соёлтой байх, аваарь осол гарсан тохиолдолд ар гэрийн амьдралыг бүрэн зохицуулах.

Г. ХАРИЛЦАХ СУБЪЕКТ, АЖЛЫН УЯЛДАА ХОЛБОО

Харилцах объект /хүрээ, уялдаа холбоо/	Байгууллагын дотор	Байгууллагын гадна
	- Гүйцэтгэх захирал - Ерөнхий инженер - Цех, хэлтэс, хэсгийн дарга, ИТА, ажилтнууд	ЭХЯ, МХЕГ, НМХГ, ЭХХТ, ОБЕГ, НОБГ, БЗДОБХ, эрчим хүчний харьяа үйлдвэрүүд, холбогдох байгууллага.

Д. ШИЙДВЭР ГАРГАХ ЭРХ МЭДЭЛ

Шийдвэр гаргах асуудал	Эрхийн хэмжээ
Хариуцсан ажлын хүрээнд	Санал гаргах, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, шаардлага, акт, тодорхойлолт төлөвлөх, хариуцсан ажлын чиглэлээр төлөвлөгөө, тайлан гаргах, хүргүүлэх.

Е. АЖИЛ ЭРХЛЭГЧДИЙН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

Ажлын үр дүнгийн талаар ажил эрхлэгчдийн хүлээх хариуцлага	Монгол улсын хууль, дүрэм, журам, заавар, стандарт, дээд газрын хууль, тогтоомж, акт болон компанийн хөдөлмөрийн дотоод журам, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохойлдолд холбогдох хууль, дүрэм, журам, гэрээний дагуу хариуцлага хүлээнэ.
	Санаатай болон болгоомжгүй хайхрамжгүй үйлдлийн улмаас өөрийн болон бусдын биед, байгууллагын өмч, хөрөнгөд хохирол учруулсан, гэмтээсэн, үрэгдүүлсэн, алдсан тохиолдолд сахилгын, захиргааны болон эд хөрөнгийн хариуцлага хүлээнэ.
	Үйл ажиллагаандаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаануудыг мөрдөж ажиллаагүй тохиолдолд холбогдох хууль, дүрэм, журам, гэрээний дагуу хариуцлага хүлээнэ.

	Ажлын цаг ашиглалт сул, таслалт, хоцролттой тохиолдолд холбогдох хууль, дүрэм, журам, гэрээний дагуу хариуцлага хүлээнэ.
	Ажилтан ажлын байрны тодорхойлолтод заагдсан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, дутагдал, зөрчил гаргасан, хариуцлага алдсан тохиолдолд холбогдох хууль, дүрэм, журам, гэрээний дагуу хариуцлага хүлээнэ.
	Байгууллагын нууц мэдээллийг бусдад задруулсан нь тогтоогдсон зэрэг тохиолдолд холбогдох хуулийн хариуцлага хүлээнэ.

Ё. АЖЛЫН БАЙРНЫ НӨХЦӨЛ, АЖЛЫН ХЭРЭГСЭЛ

Ажлын байрны нөөц, хэрэгсэл	Санхүү	Батлагдсан үндсэн цалин болон нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал урамшуулал.
	Эд хөрөнгө	Ажлын өрөө, хариуцуулсан эд хогшил болон бичиг баримт хадгалах шүгээ, компьютер, ширээ, сандал, бусад тоног төхөөрөмж, ажлын тусгай хувцас, согтуурлын хэмжээг тандагч багаж, биеийн халуун хэмжигч багаж.
	Хувь хүний хөгжил	ХАБЭА-н сургалтанд хамрагдаж мэдлэг боловсролоо дээшлүүлэх
Ажлын байрны нөхцөл		Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллана.

Ж. БАТАЛГААЖУУЛАЛТ

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫГ БОЛОВСРУУЛЖ, ХЯНАСАН: АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН ЗУХИЙН ДАРГА:...../Б.ГАН-ОЧИР/ (Гарын үсэг) БОЛОВСРУУЛСАН: ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА/Ц.МАНДАХСАЙХАН/ 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдөр	АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН: АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ/М.МӨНХӨӨ/ (Гарын үсэг) 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдөр
--	---

З.АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТТОЙ ТАНИЛЦСАН:

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙН ИНЖЕНЕР:...../Л.ЦЭЦЭГСҮРЭН/ (Гарын үсэг) /...../ (Гарын үсэг) 2023 оны ... дугаар сарын ... өдөр
